Улсын ерөнхий прокурорын 2026 оны
06 дугаар сарын 09-ний өдрийн
А/95 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

√	Прокурорын байгууллагын бүтцийг шинэчлэн батлагдсан

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Төрийн албаны тухай хууль 2017-12-07
Дагаж мөрдөх огноо:	2019-01-01
Албан тушаалын тодорхойлолтыг батлагдсан огноо:	2026-06-09

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Улсын ерөнхий прокурорын газар	Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн
Албан тушаалын нэр:	**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**
Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Сургалт, судалгааны хүрээлэнгийн захирал	Төрийн тусгай
Ажлын цаг:	**Ажлын байрны албан ёсны байршил:**
Ажлын өдрийн 8 цаг	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Г.Чагдаржавын гудамж
Хөдөлмөрийн нөхцөл:	**Онцгой нөхцөл:**
Хэвийн	Хамаарахгүй

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:
Прокурор, ажилтнуудын мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтын бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг хангуулах, эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилт, прокурорын байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр онол, арга зүй, хэрэглээний судалгаа хийх ажлыг удирдан зохион байгуулах.

Албан тушаалын зорилт:
1.Прокурор, ажилтнуудын мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтын бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг хангуулах;
2.Эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилт, прокурорын байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр судалгаа хийх ажлыг удирдан зохион байгуулах;
3.Хүрээлэнгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Прокурор, ажилтнуудын мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтын бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг хангуулах, биелэлт, үр дүнг тооцох.	Бодлого чиглэлийг тодорхойлж, үр дүнг тооцсон байна.	Г, Х, Ш
	1.2.Прокурор, ажилтнуудаас сургалтын хэрэгцээ, шаардлагын талаарх саналыг авч нэгтгэн судалж, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах.	Санал авч, хөтөлбөр төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангуулсан байна.	Х, Ш
	1.3.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу сургалтын хөтөлбөрийг боловсруулан, магадлан итгэмжлүүлэх ажлыг удирдан зохион байгуулах.	Хуульд заасны дагуу магадлан итгэмжлүүлсэн байна.	Х, Ш
	1.4.Эрдэм шинжилгээний байгууллага, их сургууль, бусад байгууллагатай хамтран олон улсын болон үндэсний хэмжээний эрдэм шинжилгээ, онол, практикийн бага хурал, сургалт, судалгаа, семинар зохион байгуулах.	Хамтарсан арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулсан байна.	Х, Ш
	1.5.Прокурорын байгууллагын сургагч багшийг бэлтгэх, тэдгээрийн мэргэжлийн хөгжлийг дэмжих ажлыг зохион байгуулах.	Сургагч багш бэлтгэх ажлыг зохион байгуулсан байна.	Х, Ш
	1.6.Прокурор, ажилтан, бусад хуульч, эрх зүйч, хууль зүйн их сургуулийн багш, оюутнуудын дунд мэргэжлийн уралдаан, тэмцээнийг дангаараа болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулах.	Уралдаан, тэмцээнийг үр дүнтэй зохион байгуулсан байна.	Х, Ш
	1.7.Бусад байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.	Г, Х
	1.8.Олон улсын болон үндэсний хурал, зөвлөгөөнд илтгэл хэлэлцүүлэх, эрдэм шинжилгээний бүтээл гаргах ажлыг удирдан зохион байгуулах.	Илтгэл хэлэлцүүлж, эрдэм шинжилгээний бүтээл гаргасан байна.	Х, Ш
	1.9.Сургалтын гарын авлага, ном товхимол, сурах бичиг гаргах ажлыг удирдан зохион байгуулах.	Удирдан зохион байгуулсан байна.	Х, Ш
	1.10.Прокурор, ажилтнуудыг магистр, докторын сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх.	Дэмжлэг үзүүлсэн байна.	Х, Ш

	1.11.Санал, хүсэлтийн дагуу захиалгат сургалтыг зохион байгуулах.	Захиалгат сургалт зохион байгуулагдсан байна.	Х, Ш
	1.12.Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар прокурорын байгууллагаас хүргүүлж буй тайлан, мэдээ, мэдээллийг боловсруулах.	Холбогдох мэдээллийг үндэслэл бүхий боловсруулсан байна.	Х
	1.13.Олон улсын гэрээ, олон улсын байгууллагын зөвлөмжийн хэрэгжилтийн тайлангийн хуралд оролцох, Засгийн газраас баталсан Ажлын хэсэгт прокурорын байгууллагыг төлөөлөх.	Прокурорын байгууллагын төлөөллийг хэрэгжүүлсэн байна.	Г
	1.14.Сургалтын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах, цахим сангийн хэвийн үйл ажиллагааг хангуулах.	Цахим сангийн хэвийн үйл ажиллагааг хангасан байна.	Х, Ш
	1.15.Прокурорын байгууллагад оюутан дадлагажих үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг хангуулах.	Журмын хэрэгжилтийг хангуулсан байна.	Х, Ш
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Улсын ерөнхий прокуророос Улсын Их Хуралд эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар хийх мэдээлэл, түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүхтэй харилцах чиглэлээр гаргах санал, дүгнэлт, тайлбарын төслийг боловсруулах.	Үндэслэл бүхий мэдээлэл, санал, дүгнэлт, тайлбар боловсруулсан байна.	Г, Х
	2.2.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Үндсэн хуулийн цэц, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагаас ирүүлсэн хууль, дүрэм, журам, зааврын төсөлтэй танилцаж санал өгөх, мөн ирүүлсэн мэдээлэл, албан бичигт тайлбар хийх, зохион байгуулалтын шаардлагатай бусад арга хэмжээг авах.	Үндэслэл бүхий санал, тайлбар боловсруулсан байна.	Х
	2.3.Эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилт, прокурорын байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр онол, арга зүй, хэрэглээний талаар судалгаа хийх ажлыг удирдан зохион байгуулах.	Судалгаа үр дүнтэй хийгдсэн байна.	Х, Ш

	2.4.Эрдэм шинжилгээ, судалгааны үр дүн, тоо баримтад дүгнэлт хийж, Улсын ерөнхий прокурор, түүний орлогчид цаашид авах арга хэмжээний талаар танилцуулж, шийдвэрлүүлэх.	Үндэслэл бүхий санал танилцуулсан байна.	Г, Х
	2.5.Судалгааны үндсэн дээр санал, зөвлөмж, аргачлал боловсруулах.	Санал, зөвлөмж, аргачлал боловсруулсан байна.	Х, Ш
	2.6.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх судалгааг Улсын ерөнхий прокурорын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж болон бусад байгууллагатай хамтран хийх.	Судалгааг хамтран хийж гүйцэтгэсэн байна.	Х, Ш
	2.7.Прокурорын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрдэм шинжилгээ, судалгааны сан бүрдүүлэх, баяжуулах.	Сан бүрдүүлж, баяжуулсан байна.	Х, Ш
	2.8.Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх, прокурорын хяналтын ажлын чиглэлээр аргачлалыг чиг үүрэг бүхий нэгжтэй хамтран боловсруулах.	Аргачлал боловсруулсан байна.	Х, Ш
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Хүрээлэнгийн прокурор, ажилтны хариуцах ажлын хуваарийг гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих.	Ажлын гүйцэтгэл, үр дүнг тооцсон байна.	Х, Ш
	3.2.Хариуцсан ажлын мэдээ, тайланд дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлт, үр дүнг тооцох.	Мэдээ, тайланд дүн шинжилгээ хийж, ажил, арга хэмжээний санал гаргасан байна.	Х, Ш
	3.3.Хүрээлэнгийн шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, үүрэг даалгаврын биелэлт, үр дүнг тооцох.	Үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулсан байна.	Х, Ш
	3.4.Хүрээлэнгийн хэмжээнд шаардлагатай бүртгэл, судалгааг хөтлүүлж, хяналт тавих.	Бүртгэл хөтлөлтөд хяналт тавьсан байна.	Х
	3.5.Хүрээлэнгийн ажилтай холбоотой мэдээ, мэдээлэл бэлтгэж, олон нийтэд хүргэх арга хэмжээ авах.	Мэдээ, мэдээллийг бэлтгэж, олон нийтэд хүргэсэн байна.	Х
	3.6.Хүрээлэнгийн чиг үүрэгт хамаарах асуудлаар зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдтэй хамтран ажиллаж, байгууллагын бодлого, зорилтыг уялдуулах.	Ажлын уялдаа холбоог хангасан байна.	Г, Х, Ш
	3.7.Хариуцсан ажлын чиглэлээр Улсын ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөлийн хуралдаанд асуудал хэлэлцүүлэн, шийдвэрлүүлэх.	Шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г

	3.8.Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нараас өгсөн үүргийг хэрэгжүүлж, хариуцсан чиг үүрэгтэй холбоотой мэдээллээр хангах.	Үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж, мэдээллээр хангасан байна.	Г
	3.9.Архив, албан хэрэг хөтлөлтийн ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, заавар, журам, стандартын хэрэгжилтийг хангах.	Хэрэгжилтийг хангасан байна.	Х
	3.10.Хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журам, Улсын ерөнхий прокурорын тушаалаар хариуцуулсан чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль, заавар, журамд заасан чиг үүрэг хэрэгжсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	Эрх зүй (0421)	
Мэргэшил	-хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээтэй байх -хуульчийн багц цагийн сургалтад хамрагдсан байх	
Туршлага	Дээд шатны прокуророор 3-аас доошгүй жил, эсхүл Улсын ерөнхий прокурорын газарт ахлах прокуророор ажилласан байх	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	-хариуцсан ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; -прокурор, ажилтанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх; -эрсдлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх.
	Дүн шинжилгээ хийх	-мэдээллийг цуглуулж, шалган нягтлах; -шийдвэрийн үр дагавар, эрсдлийг үнэлэх; -судалгааны арга зүйг ашиглан санал, дүгнэлт боловсруулах.
	Асуудал шийдвэрлэх	-хариуцсан ажлын явцад үүссэн асуудал, хүндрэл бэрхшээлийн шалтгаан, нөхцөлийг бодит мэдээлэлд үндэслэн тогтоох; -шийдвэрийн үр дагавар эрсдлийг урьдчилан тооцоолох; -хууль тогтоомжид нийцсэн оновчтой шийдвэр гаргах; -гаргасан шийдвэрийн хариуцлагыг хүлээх.
	Манлайлах	-прокурор, ажилтнуудыг үлгэрлэн манлайлах; -ажлын байрны эерэг орчныг бүрдүүлэх; -шинэ санаачилга болон өөрчлөлтийг дэмжих.
	Багаар ажиллах	-хамтын шийдвэр гаргалтад идэвхтэй оролцох; -хариуцсан ажлыг багийн зорилготой уялдуулан хэрэгжүүлэх; -мэдээллийг нээлттэй хуваалцах; -бусдын санал бодлыг хүндэтгэх.
	Бусад	-баримт бичиг боловсруулах; -хууль хэрэглэх; -ажлын ачааллыг оновчтой төлөвлөж, эрэмбэлэн зохион байгуулах; -албан хэрэгцээнд шаардлагатай мэдээллийн систем, программ хангамжийг ашиглах, мэдээллийг цахим орчинд боловсруулах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Улсын ерөнхий прокурор, түүний орлогч

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект:
1. Сургалтын албаны дарга, ахлах прокурор 2. Судалгааны албаны дарга, ахлах прокурор 3. Сургалт, судалгааны хүрээлэнгийн хяналтын прокурор 4. Сургалт, судалгааны хүрээлэнгийн захиргаа, үйлчилгээний ажилтнууд Нийт: 4	1.Нэгж прокурорын газрын прокурор, ажилтан 2.Төрийн байгууллага 3.Иргэн, хуулийн этгээд

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТУСЛАХ ПРОКУРОР, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ХҮЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХТУЯА 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр	Байгууллагын нэр: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Дугаар: 2

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР
Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар: А/95

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦАА[illegible]
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ Б.ЖАРГАЛСАЙХАН

2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр